

**ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /8-р сарын 28-нөөс 9-р сарын 25-ны байдлаар, төгрөгөөр/**

№	Барааны нэр, төрөл	VIII/28	IX/04	IX/11	IX/18	IX/25
1	Гурил, I зэрэг, кг	650	650	650	650	650
2	Хонины мах, кг/ ястай/	6800	6500	6800	6500	6800
3	Үхрийн мах, кг /ястай/	7500	7500	8000	8000	8500
4	Ямааны мах /ястай /	6000	6000	6000	6000	6000
5	Элсэн чихэр, кг	1480	1480	1550	1550	1550
6	Цагаан будаа, кг	1800	1800	2000	2000	2000
7	Шингэн сүү, л	700	800	750	750	800
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан					
9	- Бор ноолуур					
10	Бензин, А-80, 1 литр	1550	1550	1550	1550	1550
11	Бензин, А-92, 1 литр	1650	1650	1650	1650	1650
12	Дизелийн түлш, 1 литр	1750	1750	1750	1750	1750

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2013 оны 8-р сарын 28-наас 9-р сарын 25-ны хооронд гурил, ямааны ястай мах, шатахууны үнэ тогтвортой байж бусад бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөв. Энэ хугацаанд ноолуурын арилжаа хийгдсэнгүй.

**Махны үнэ.** Хонины ястай мах 1 кг нь 8-р сарын 28, 9-р сарын 11, 25-нд 6800 төгрөг байсан бол 9-р сарын 4, 18-нд 4,41%-аар буурч 6500 төгрөг болов. Үхрийн ястай мах 1 кг нь 9-р сарын 11-нд 8000 төгрөг болж өмнөх хоёр 7 хоногийн үнэнээс 500 төгрөгөөр өссөн нь 6,67%-ийн өсөлт байв. 9-р сарын 25-нд 8500 төгрөг болж дахин 500 төгрөгөөр өсөв. Ямааны ястай махны үнэ 6000 төгрөг болж энэ ханш хадгалагдсан хэвээр байна.

**Цагаан будаа.** 1 кг цагаан будааны дундаж үнэ 8-р сарын 28-нд 1800 байсан бол 9-р сарын 11-нээс 11,1%-аар өсч 2000 төгрөгийн ханштай болов.

**Шингэн сүү.** Хүйтний улирал ирж буйтай холбоотойгоор шингэн сүүний нийлүүлэлт багасч үнэ нь өсч байна. 9-р сарын 4-нд 1 литр сүүний үнэ өмнөх 7 хоногийн үнэнээс 100 төгрөгөөр нэмэгдэж 800 төгрөг болов.



